

“/_____/” ХХК

“/_____/” ХХК

Хоорондын

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Худалдагч

Худалдан авагч

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

_Он _ сар _ өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хууль бусад хууль тогтоомжийн дагуу нэг талаас ”_____” “ХХК /Цаашид худалдагч гэх/ нөгөө талаас “_____” ХХК /цаашид Худалдан авагч гэх/-ийн хооронд /Цаашид хамтад нь “Талууд” гэх/ дараах зүйлүүдийг хэлэлцэн тохиролцож байгуулав.

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Монгол Улсын “_____” ХХК болон “_____” ХХК-ны хооронд байгуулсан “_____ худалдах, худалдан авах” тухай гэрээг хэрэгжүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1 Талууд энэхүү гэрээний үндэслэн болгосон баримт бичгийн үзэл санааг хэрэгжүүлж олон улсын худалдааны зарчимд нийцсэн, холбогдох хууль тогтоомжийг баримтлан хамтын ажиллагаагаа боловсронгуй болгон харилцан ашигтай ажиллаж, _____ худалдах, худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2 Энэхүү гэрээг нийлүүлэх _____ чанар нь _____ стандартын шаардлагыг хангана.

2.3 Талууд гэрээгээр тохиролцсон үнэ, хэмжээ, нөхцөлөөр _____ нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.4 Худалдагч, худалдан авагчид энэхүү гэрээний дагуу 20_ оны _ дугаар сарын _ -ний өдөр хүртэлх хугацаанд _____ хүртэлх /_____ тн, _____ тн/ _____ нийлүүлнэ. Худалдагч энэ тоо хэмжээг нэмэгдүүлэх эрхтэй.

2.5 Худалдан авагч тал гэрээг бүрэн биелүүлсэн нөхцөлд энэхүү гэрээг цаашид үргэлжлүүлэн сунгах, нийлүүлэх _____ хэмжээг дахин тохиролцож байна.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ,

3.1 Энэхүү гэрээгээр нийлүүлэгдэх _____ үнэ нь _____ нөхцөлийг жишиг болгон _____ тонн

Худалдагч

Худалдан авагч

тугамд _____ тус бүр
_____ ам доллароор тооцоо хийнэ.

3.1 Энэхүү үнэнд “_____” ХК-д _____ нөхцөлөөр төлөх
_____ төлбөр, ашиглалтын төлбөр, _____ Улсын хилийн
доторх удирдлага, зохион байгуулалт болон тээвэрлэлт,
хадгалалт, хамгаалалт, шилжүүлэн ачилтын, ачааг пүүлэх
төлбөр багтсан болно.

3.3 Олон улсын зах зээл дахь _____ үнэ, өөрчлөгдсөн болон
“_____” ХК буюу эрх бүхий байгууллагуудаас
_____ үнэ, _____, хил, гаалийн татвар хураамжийг
албан ёсоор өөрчилбөл хоёр тал тохиролцож дээрх үнийг
талууд тохиролцож өөрчилж болно. Энэ тухай худалдагч тал
худалдан авагч талд _____ хоногийн дотор албан ёсоор
мэдэгдэж байна.

3.4 Энэхүү гэрээний нийт үнийн дүн _____ мянган ам/
доллар байна.

ДӨРӨВ: ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

4.1 Худалдан авагч нь энэхүү гэрээний дагуу 20—оны--
дугаар сард нийлүүлэх _____ үнийн урьдчилгаа
_____ ам.доллар Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс
хойш ажлын /_____/ хоногийн дотор Худалдагчийн дансанд
хийнэ.

4.2 Эхний удаа нийлүүлэх _____ тн _____ үнэ болох
_____ ам.долларыг Талууд гэрээнд гарын үсэг
зурсан өдрөөс хойш ажлын _____ хоногийн дотор
Худалдагчийн дансанд урьдчилан шилжүүлнэ. Энэхүү эхний
_____ тн _____ Худалдан авагч дараагийн
_____ тн _____ төлбөрийг шилжүүлнэ

4.3 Мөнгө шилжүүлэх байгууллагуудын нэр болон мөнгөний
үнийн дүнг _____ ХХК жич албан тоотоор
мэдэгдэж байна.

4.4 Энэхүү гэрээний 4.1, 4.2-т заасан төлбөрийг Худалдан
авагч хийгээгүй нөхцөлд гэрээнд заасан _____
тохиолдолд нийлүүлэлт зогсоно.

4.5 Худалдан авагч талын хүлээн авагч компани нь гэрээгээр
авах _____ нөхцөлөөр төлбөрийг _____ ХХК-ийн
дансанд төлнө. _____ ХХК-ийн төлбөр хүлээн авах
дансны дугаар: _____ банкны нэр _____ тоот

Худалдагч

Худалдан авагч

ам.долларын эсвэл _____ тоот юанийн дансанд шилжүүлнэ.

ТАВ: ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Худалдан авагч нь: - хил гарталх, хилээс очих газар хүртэлх бүх тээврийг хийх ба тээврийн машинтай холбогдох бүх зардлыг хариуцна.

Гаалийн баталгаат талбайд нөөцлөгдсөн _____ хэмжээг _____ тн – оос илүүгүй байхаар татан авч байна. Талбайд буусан _____, _____ хоногоос хэтрүүлэлгүй татаж авах үүрэг хүлээнэ.

Өөрийн төлөөлөгчөөр дамжуулан хяналт тавьж болно.

Худалдан авагч тал гаалийн хяналтын талбай хүртэл өөрийн _____ тээвэрлэж байгаа нөхцөлд тээврийн машиныг худалдан авагч талын удирдлаган дор ажиллуулах ба тухайн машины жолоочийн буруутай үйлдлээс болж гарсан алдагдлыг Худалдан авагч тал бүрэн хариуцна.

Худалдагч талын зааж өгсөн талбайд _____ нөөцөлж байна.

5.2 Худалдагч нь: - Гэрээний нөхцөлийн дагуу чанар стандартад нийцсэн _____ заасан тоо хэмжээгээр худалдан авагч талд хүлээлгэн өгнө.

_____ экспортлохтой холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлэн хил гаалиар өнгөрүүлж холбогдсон хил, гаалийн хураамжийг төлнө.

Худалдан авагчийн _____ ачихаар ирсэн машиныг хүлээлгүйгээр ачилтад оруулах үүргийг хариуцна.

Энэхүү гэрээний дагуу төлбөр хийгдээгүй тохиолдолд зогсооно.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА БА МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1 Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд талууд гэрээгээр гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хоног тутамд _____ хувийн алданги тооцно.

6.2 Хэрэв худалдан авагчийн үйл ажиллагаанаас хамаарч Гаалийн хяналтын талбай дахь 15 хоногийн дундаж нөөц ихэссэн, ачилт хийхгүй 15-аас илүү хоносон бол нөөцөөс хэтэрсэн _____ хэмжээ болон тээвэрлээгүй _____ илүү гарсан хоног тутамд Худалдагч талд _____ тн хадгалалтын

Худалдагч

Худалдан авагч

хөлсийг _____ ам.доллараар тооцож Худалдан авагч тал төлж байна.

6.3 Худалдагч талын буруугаас гаалийн хяналтын талбайд ирсэн машиныг _____ илүү хоногоор саатуулсан бол саатуулсан хоног тутамд ачих байсан _____ үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг худалдан авагч талд төлж байна.

6.4 Худалдагч тал худалдан авагч талд нийлүүлсэн _____ нь 2.2 дугаар заалтад дурдсан чанарыг хангаж чадаагүй нь тогтоогдсон тохиолдолд шаардлага хангасан _____ сольж нийлүүлнэ.

6.5 Энэхүү гэрээний 4.1, 4.2 – д заасны дагуу урьдчилгаа төлбөр хийгээгүй нөхцөлд _____ бөгөөд үүнээс гарах хохирлыг Худалдагч хариуцахгүй.

6.6 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй өөр бусад нөхцөл үүсэх тохиолдолд нөгөө талдаа энэ тухайгаа бичгээр яаралтай мэдэгдэнэ.

6.7 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад ямар нэгэн маргаан гарвал найрсаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд ингэж шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол улсын Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Арбитраар маргааныг эцэслэн шийдвэрлүүлнэ.

6.8 Хэрэв аль нэг тал энэхүү гэрээний дагуу биелүүлэх үүргээ, нөхцөлийг хэсэгчлэн болон бүрэн гүйцэтгэж чадахгүйд хүрвэл нөгөө талдаа энэ тухай урьдчилан бичгээр мэдэгдэж тодорхой арга хэмжээ авна.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ НӨХЦӨЛ

7.1 Энэхүү гэрээний дагуу _____ нийлүүлэх явдал газар хөдлөлт, гал, усны аюул зэрэг олон улсын худалдааны _____ нөхцөлийн дагуу давагдашгүй нөхцөл бий болж тасалдахад хүрвэл Талууд энэхүү гэрээний үйлчлэх хугацааг түр зогсоож дахин сунгах талаар харилцан тохиролцоно.

7.2 Давагдашгүй нөхцөл үүссэн хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргийг үл биелүүлсний хариуцлага хүлээхгүй бөгөөд гэрээг зогсоож, түдгэлзүүлэх, аль эсвэл сунгах асуудлыг жич ярьж шийдвэрлэнэ.

НАЙМ. БУСАД НӨХЦӨЛ

Худалдагч

Худалдан авагч

8.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болж _____сарын хугацаатай байна.

8.2 Энэхүү гэрээний 4.1, 4.2 – т заасан нөхцөлийг Худалдан авагч тал биелүүлээгүй тохиолдолд Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш заалт бүрийн дагуу ажлын _____хоногийн дараа хүчингүй болсонд тооцно.

8.3 Гэрээнд заасан нөхцөлүүдийг хоёр тал харилцан биелүүлнэ.

8.4 Гэрээнд оруулах аливаа өөрчлөлтийг бичгээр үйлдэж хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулна. Гэрээг _____хэл дээр тус бүр _____хувь үйлдэв.

ЕС. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

9.1. Аль нэг Тал компанийн бизнес төлөвлөгөө болон энэ гэрээний дагуу мэдэх болсон бусад Талуудын бизнесийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд нууцлал задруулбал энэ гэрээний 6 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ

АРАВ.ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

10.1 Талууд гэрээ байгуулах өдрийн байдлаар дараах албан ёсны хаягт байрлаж байгаа бөгөөд хаяг өөрчлөгдсөн тохиолдолд нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ:

10.1.1 Нийлүүлэгч тал:

Хаяг: _____,

Утас/Факс: _____,

Банкны данс: _____,

10.1.2 Худалдан авагч тал:

Хаяг _____,

Утас/Факс: _____,

Банкны данс: _____,

Худалдагч

Худалдан авагч

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ХУДАЛДАГЧ

ХУДАЛДАН АВАГЧ

Худалдагч

Худалдан авагч
